



Дугаар #11

2011 оны 11 сарын 11

СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ, УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГЫН МЭДЭЭЛЭЛ

Сайн байцгаана уу,

Лхагва гарагт болсон эцэг эхийн хуралд олон эцэг эхчүүд ирж оролцож байгааг харахад сайхан байлаа. Энэ хурлын үеэр та бүхэн багш нартай хүүхдийнхээ сурлага, хүмүүжлийн талаар ярилцаж уулзалтыг үр дүнтэй болгож чадсан гэдэгт итгэлтэй байна.

Та бүхэнд хоёр чухал арга хэмжээний талаар дахин сануулъя:

- 1) ОУДС-ийн **Олон Улсын 7 хоногийн** өдрүүд Ням гарагийн 16:00 цагт эхэлнэ.
- 2) ОУДС-ийн **Жилийн Ерөнхий Хуралдаан (ЖЕХ)** Пүрэв гарагт 18:00 цагаас кафетерияд болно.

Энэ долоо хоногийн Мэдээнд бид 5 жилийн Стратеги төлөвлөгөөний сүүлийн 2 зорилтуудын талаар та бүхэнд товч мэдээлэл өгье. ОУДС-иас дараагийн 5 жилд хийх ажлыг тодорхойлсон энэ төлөвлөгөөний талаар бид та бүхэнд сүүлийн гурван Мэдээгээр дамжуулан мэдээлэл хүргэж байгаа.

| 5-р Зорилго-Элсэлт, Маркетингийн талаар | 6-р Зорилго-Удирдлагын талаар |
|---|---|
| <p>Бид манай хөтөлбөрийг судлах чадвартай манай сургуулийн эрхэмлэдэг зүйлсийг хүлээн зөвшөөрсөн олон орны сурагчдыг элсүүлэн суралцуулах бодлого баримтална.</p> <p>Зорилтууд:</p> <ul style="list-style-type: none"> • Тухайн сурагч ОУДС-ийн хэрэгжүүлдэг хөтөлбөрийг судлах чадвартай эсэхийг үнэлэх элсэлтийн тодорхой, тэнцвэртэй бодлого журмыг боловсруулах • Технологийн дэвшилтэй холбосон маркетингийн шинэ стратегийг ашиглан сургуулийн нийт хамт олонд болон шинээр ажилд орох багш нарт мэдээллийг тогтмол хүргэж байх | <p>ОУДС-ийн үйл ажиллагааг олон үндэстнээс бүрдсэн эцэг эхийн төлөөлөл болох Удирдах Зөвлөлийн гишүүд удирддаг бөгөөд тэд хоёр жилийн хугацаатайгаар сонгогддог. Удирдах Зөвлөл бодлого боловсруулж энэхүү бодлогын хэрэгжилтийг хянах хариуцлага хүлээдэг бөгөөд стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийн үр дүнгээр өөрсдийн ажлыг хэмждэг.</p> <p>Зорилтууд:</p> <ul style="list-style-type: none"> • Удирдах Зөвлөл нь ОУДС-ийн нийт эцэг эхийн өмнө хүлээсэн үүргийн дагуу тависан зорилгоо хэрэгжүүлэх • Удирдах Зөвлөл өөрсдийн ажилд стратеги төлөвлөгөөг хэрхэн хэрэгжүүлж байгаа талаар тогтмол үнэлгээ хийх • Төлөвлөлтийн үйл явцыг үр дүнтэй болгох • Багш ажилтнууд, эцэг эхчүүдтэй тогтмол харилцаатай байх |

THE MEDEE

The Weekly Newsletter of the International School of Ulaanbaatar

Зорилгоо хэрэгжүүлэхээр бид юу хийж байна вэ?

Стандартын тест ашиглан шинээр элсэгчдийн англи хэлний мэдлэгийн түвшинг тогтоож манай сургуулийн хөтөлбөрийг Англи хэл дээр судалж чадах эсэхийг нь тодорхойлж байгаа. Элсэлтийн бодлого журмаа сургуулийн эрхэмлэх зүйлс, боловсролын бодлоготой уялдуулан өөрчилж байгаа. Улаанбаатарт гадны хөрөнгө оруулалттай сургуулиудын тоо нэмэгдэж байгаатай холбогдуулан бид сургуулийнхаа маркетингийн стратегийг зах зээлийн хэрэгцээнд нийцүүлэн эцэг эхчүүдэд өөрсдийн талаарх мэдээллийг тодорхой байнга хүргэх бодлого баримталж байна.

Зорилгоо хэрэгжүүлэхээр бид юу хийж байна вэ?

Бид стратеги төлөвлөгөөний зорилтуудаа Удирдах Зөвлөлийн үйл ажиллагааны гол цөм болгон тодорхойлсон. Стратеги төлөвлөгөөний зургаан үндсэн зорилгын дагуу Удирдах Зөвлөл, Багш ажилчдын 6 дэд хороог байгуулж тэд өөрсдийн хийх ажлын зорилтуудыг тодорхойлон ажиллаж байна.

Удахгүй болох ЖЕХ дээр Удирдах Зөвлөл багш ажилтнуудын хоорондын харилцааг сайжруулах талаар дүрмэнд өөрчлөлт оруулахаар төсөл бэлтгэж батлуулахад бэлэн болоод байна.

Удирдах Зөвлөлийн залгамж халааг бэлтгэх ажлыг сайжруулах төлөвлөгөөг удахгүй боловсруулж хэлэлцэнэ.

Та бүхэнтэй Ням гарагт уулзацгаая!

Захирал Robert Stearns, Удирдах Зөвлөлийн Дарга Shane Rosenthal

ХУАНЛИД ТЭМДЭГЛЭХ ӨДРҮҮД:

- | | |
|----------------|---|
| 11 сарын 13 | ЭББ-ийн Олон Үндэстний Хоолны өдөрлөг 16:00-19:00 зөвхөн гэр бүлийн гишүүд оролцоно |
| 11 сарын 14-18 | Олон Улсын Долоо Хоног |
| 11 сарын 14 | Нийт сургуулийн өдөрлөг-8:30-д сургуулийн заланд |
| 11 сарын 17 | Олон улсын долоо хоногийн өдөрлөг-Олон Үндэстний жагсаал-8:30-д сургуулийн заланд |
| 11 сарын 17 | ОУДС-ийн нийт эцэг эхчүүдийн Жилийн Ерөнхий Хуралдаан-18:00 |
| 11 сарын 29 | 5-р ангийн сурагчид, тэдний эцэг эхчүүдэд үзэсгэлэнгийн талаар мэдээлэл хийх уулзалт сургуулийн номын санд-8:30 |

Хурлын өмнөх арга хэмжээ 18:00 цагт кафетерияд болно

1. Хоол, Хөнгөн зууш
1. Санхүүгийн товч мэдээлэл (18:10-д номын санд)
2. ОУДС-ийн сурагчдын тоглолт (Кафетерияд 18:40)

Хурлын хэлэлцэх асуудлууд-19:00 кафетерияд

1. Хурлыг нээж Удирдах Зөвлөлийн Дарга
-Shane Rosenthal үг хэлнэ
2. Хурлын протоколд гарын үсэг зурах хоёр гишүүний сонгууль
3. Сургуулийн Удирдлагын Бүтцийн товч танилцуулга, Жилийн Ерөнхий Хуралдааны зорилго
-Shane Rosenthal
4. Аудитын Тайлан
-Санхүүгийн Хороон дарга Helge Reitz
5. Стратеги төлөвлөгөөг бид хэрхэн хэрэгжүүлж байна вэ?
-ОУДС-ийн Захирал Robert Stearns
6. ОУДС-ийн сургуулийн барилгын өргөтгөлийн танилцуулга
-David Croteau Flansburgh Архитекторын компанийн захирал
7. Нийгэмлэгийн Дүрмэнд өөрчлөлт оруулах
-Shane Rosenthal
8. Сургуулийн Удирдах Зөвлөлд нэр дэвшигчдийн танилцуулга*
9. Удирдах Зөвлөлийн гишүүдийн сонгууль**
10. Асуулт, Хариулт
11. Сонгуулийн санал хураалтын үр дүнгийн танилцуулга
12. Хурлын Хаалт

*Ирэх долоо хоногийн эхээр бид e-мэйлээр Удирдах Зөвлөлд нэр дэвшигчдийн талаарх товч мэдээллийг та бүхэнд хүргэх болно. Энэ мэдээлэл мөн манай вэбсайтад тавигдах болно.

**Хэрэв та бүхэн өөрсдийн биеэр хуралд ирж оролцох боломжгүй бол Мэдээнд хавсаргасан (7-р хуудас) итгэмжлэгдсэн хүнээр дамжуулж санал өгөх хуудсыг бөглөж сургуулийн ресепшинд ирүүлэх буюу 11-17-нд хуралд ирэх хүнээр дамжуулж бидэнд ирүүлээрэй.

Олон Улсын Долоо Хоног – 2011 оны 11 сарын 13 – 18

Эрхэм хүндэт эцэг эхчүүд ээ

Манай сургууль олон улсын долоо хоногийн өдрүүдийг удахгүй тэмдэглэх гэж байна. Даяаршсан нийгэмд өөрсдийн байр суурийг олж тодорхойлохын тулд манай сурагчид энэ долоо хоногийн үеэр зохиогдох олон талт арга хэмжээний үеэр интернационалч үзэл болон олон орны соёлын талаар илүү дэлгэрэнгүй мэдээлэл олж авах болно.

11 сарын 13-ны Ням гарагт ЭББ олон үндэстний хоолны өдөрлөгийг 16:00-19:00 цагийн хооронд зохион байгуулна.

11 сарын 14-ний Даваа гарагт 8:30-д болох Монгол орны соёл заншлыг сурталчлах өдөрлөгт та бүхэн хүрэлцэн ирээрэй. Энэ өдөр та бүхэн Монгол үндэсний хувцас өмсөөрэй.

11 сарын 17-ны Пүрэв гарагт 8:30-д болох Олон Үндэстний Жагсаалд та бүхэн ирж оролцоорой. Энэ өдөр та бүхэн хүүхдүүддээ үндэсний хувцсыг нь өмсгөөрэй.

Энэ жилийн олон улсын өдрүүдээр бид дараах сэдвүүдийг судална:

| | |
|----------------|----------------------------|
| Даваа гарагт: | Монгол орны Соёл заншил |
| Мягмар гарагт: | Соёл заншил гэж юу вэ? |
| Лхагва гарагт: | Даяаршсан нийгмийн иргэн |
| Пүрэв гарагт: | Олон Үндэстнүүдийн Жагсаал |
| Баасан гарагт: | Дүгнэлт |

Та бүхэн эдгээр сэдвүүдийн хүрээнд хүүхдүүдтэйгээ ярилцаж дараах вэб хуудаснуудаас мэдээлэл аваарай. Та бүхэнд асуулт байвал багш Maggie Dawson (m.dawson@isumongolia.edu.mn), багш Эрдэнэцэцэг (e.bayandorj@isumongolia.edu.mn) нартай холбоо бариарай. Та бүхэнтэй олон улсын долоо хоногийн өдрүүдээр уулзацгаая!

Maggie Dawson

INTERNET RESOURCES – INTERNATIONALISM and INTERCULTURALISM

Culture

Third Culture Kids blog with many links:<http://3rdculturekids.blogspot.com/>

Third Culture Kids:<http://www.telegraph.co.uk/education/expateducation/6545869/Third-culture-kids.html>

What is culture?http://anthro.palomar.edu/culture/culture_1.htm

Global issues

UN global issues:<http://www.un.org/en/globalissues/>

Very comprehensive site:<http://www.globalissues.org/>

Some games and quizzes

Flag tag:http://www.cyberschoolbus.un.org/flagtag/frm_ft_intro.asp?score=0&screen_height=800

Geography quiz:<http://www.un.org/cyberschoolbus/quick/qqs.asp>

Capitals quiz:<http://www.freeflour.com/>

Эдгээр линкүүдийн мэдээллийг өгсөн багш Mr. Chilton-д баярлалаа.)

!Олон Үндэстний Хоолны Өдөрлөг!

2011 оны 11 сарын 13-ны Ням Гаргаг

Олон Улсын Долоо Хоногийн Эхлэл!

16:00 – 19:00 цагт ОУДС дээр

Та бүхний анхааралд:

ЭББ-ийн гишүүд та бүхэнтэй утсаар болон e-мэйлээр холбоо барьж ямар хоол авчрахыг тань хэлж өгнө.

Та 16:00-д цагтаа ирээрэй! Тоглолт 16:30-д эхэлж хоолны өдөрлөг 19:00 цагт дуусна.

Энэ бол ОУДС-ийн үйл ажиллагаа. Зөвхөн гэр бүлийн гишүүд ирнэ. Найз нөхдөө дагуулж ирэхгүй байхыг анхааруулж байна.

Арга хэмжээнд оролцох эсэхээ баталгаажуулах хуудсыг бид сурагчдаар өгч явуулах болно.

ДУНД СУРГУУЛИЙН МЭДЭЭ

Дунд сургуулийн Халловин-ы бүжиг амжилттай болж өнгөрлөө. Энэ арга хэмжээг зохион байгуулсан сурагчдын зөвлөлийн хамт олонд баяр хүргэе. Та бүхэн өөр ямар арга хэмжээ зохиомоор байгаа талаарх өөрсдийн санал бодлыг сурагчдын зөвлөлийхөнтэй хуваалцаарай.

Волейболын тэмцээний улирал дуусч сагсны тэмцээний улирал эхэлж байна. Дасгалжуулагч багш Ramar, Mewbourn нартаа шинэ тамирчдыг дасгалжуулах ажилд нь амжилт хүсье.

Дунд сургуулийн сурагчид байгалийн шинжлэлийн хичээлээр тахианы хөлд зүсэлт хийж, дизайн технологийн хичээлээр агуулахын өрөө барьж байна. Та бүхэн хүүхдүүдээсээ өөрсдөөс нь юу сурч мэдсэн талаар нь асуугаарай.

Энэ долоо хоногт болсон эцэг эхийн хуралд ирж оролцсон эцэг эхчүүддээ баярлалаа. Олон эцэг эхчүүд ирж хүүхдийнхээ сургалтын талаар багш нартай уулзаж ярилцаж байгааг харахад бидэнд сайхан байдаг. Хүүхдүүддээ өгч чадах бидний хамгийн чухал зүйлсийн нэг бол тэдний боловсролын асуудалд гэрийхэнээс нь дэмжлэг үзүүлэх явдал юм.

Амралтын өдрүүддээ сайхан өнгөрүүлээрэй. Эрүүл мэнддээ сайн анхаарч өвдөхгүй байгаарай.

Дунд Сургуулийн Эрхлэгч Betsy Hanselmann

БАГА СУРГУУЛИЙН МЭДЭЭ

Ангиудаар айлчилж сурагчдыг юу сурч, хичээлдээ хэрхэн оролцож байгааг ажиглах нь миний ажил үүргийн нэг хэсэг байдаг юм. Энэ долоо хоногт 1-р ангийн сурагчид судалж буй сэдвийн хүрээнд гэр бүлийн түүхийг харуулсан ном хийж завгүй ажиллаж байлаа. Тэд өөрсдийн бага насандаа гэр бүлийхэнтэйгээ авахуулсан зурагнуудаа надад танилцуулсан. Олон орноос ирсэн сурагчдынхаа зургийг үзэж түүхийг нь сонсож байхдаа ОУДС-ийн хамт олон бид ийм олон орны соёл заншлаас суралцдаг сайхан боломжтой гэдгээр бахархаж байлаа.

Олон Үндэстний Хоолны Өдөрлөгийн үеэр та бүхэнтэй Ням гарагт уулзацгаая!

Бага Сургуулийн Эрхлэгч Rick Elya

5-р ангийн сурагчид Skype-аар ярилцлага хийлээ.

5-р ангийн сурагчид АНУ-ын Миссури мужийн Сайнт Луйс хотын зар сурталчилгааны агентлагийн захирал, Webster-ийн Их Сургуулийн профессор Marc Cheshik-тэй skype-аар ярилцлага хийлээ. Сурагчид маань зар сурталчилгаа хэрхэн хийх талаар суралцаж байгаа бөгөөд ноён Cheshik сурагчдын сонирхсон асуултанд хариулж өөрийн хийсэн зар сурталчилгаанаас танилцуулж хүүхдүүдтэйгээ манай сурагчдыг яриулсан. Тэд хоорондоо ярилцаж АНУ болон Монголд сагсан бөмбөг, хөл бөмбөг түгээмэл дэлгэрсэн спортууд болохыг мэдэж авлаа. Хичээлийн сэдвийн дүгнэлт болгож 5-р ангийн сурагчид Пүрэв гарагт өөрсдийн зар сурталчилгааны бичлэгийг хийсэн.

Багш Liz Covington

ОУДС-ийн Хөл Бөмбөгийн Тэмцээн

ОУДС-ийн хамт олны удаан хүлээсэн хөл бөмбөгийн тэмцээн 11 сарын 5-нд 5-р сургуулийн талбайд боллоо. Цаг агаар сайхан дулаахан байсан бөгөөд тэмцээн амжилттай болж өнгөрсөн. Тэмцээнд 8 баг оролцож Bosses баг түрүүлж киноны билетээр шагнуулсан. Тэмцээнд оролцсон бүх баг тамирчиддаа баярлалаа. Тэмцээнийг зохион байгуулахад тусалсан Mr. McCutcheon, Mrs. Hanselmann нарт талархал илэрхийлье. Энэ тэмцээний үеэр цугларсан 164,000 төгрөгийн хандивыг улсын асрамжийн газарт хандивлана. Тэмцээний талаарх дэлгэрэнгүй мэдээллийг Мэдээний англи эх хувиас уншиж сонирхоорой.

Сурагч Sung Eun Kweon



**2011 ISU ANNUAL MEETING
PROXY VOTE FORM**

Copy the following sentence in your own handwriting below – “I.....(write your name) hereby authorize(insert the name of the person who will vote on your behalf) to vote on my behalf at the 2011 ISU Annual Meeting.”

Then please write your signature below the sentence, and date it for the day of the Annual meeting.

.....
.....
.....
.....

SIGNATURE:..... DATE:.....

**ОУДС-ийн 2011 оны ЖИЛИЙН ЕРӨНХИЙ ХУРАЛДААН
ИТГЭМЖЛЭГДСЭН ХҮНЭЭР ДАМЖУУЛЖ САНАА ӨГӨХ ХУУДАС**

Дараах өгүүлбэрийг өөрийн гараар хуулж бичнэ үү-“ОУДС-ийн 2011 оны Жилийн Ерөнхий Хуралдаан дээр(таныг төлөөлж санал өгөх хүний нэрийг бичнэ үү) намайг төлөөлж миний өмнөөс санал өгөхийг би (өөрийнхээ нэрийг бичнэ үү) зөвшөөрч байна.”

Дараа нь энэ өгүүлбэрийнхээ дор нь гарын үсгээ зурж хурал болох он сар өдрийг бичнэ үү.

.....
.....
.....
.....

ГАРЫН ҮСЭГ:..... ОГНОО:.....